



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/434

Мандалговь

Аймгийн онцгой комиссын бүрэлдэхүүн,
ажиллах журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 23 дугаар зүйлийн 23.3, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 152 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг аймгийн нутаг дэвсгэрт удирдан зохион байгуулах үүрэг бүхий аймгийн Онцгой комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Онцгой комиссын гишүүдийн нэр, гэрийн хаяг, утасны жагсаалтад тодотгол хийж аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгаж, холбоо зарлан мэдээллийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Онцгой комиссын нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

3. Аймгийн нутаг дэвсгэрт гамшгаас хамгаалах ажлыг зохион байгуулахад удирдлага, зохион байгуулалтаар хангаж, тухай бүр танилцуулж ажиллахыг Онцгой комиссын орлогч дарга нарт даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан Онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журам, ажлын хэсгүүдийн шинэчлэн батлах тухай 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/434 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100725

Аймгийн Засаг даргын 2023 оны 05
дугаар сарын 03-ны өдрийн 1/24
дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: - Аймгийн Засаг дарга
- Орлогч дарга: - Аймгийн Засаг даргын орлогч
- Онцгой байдлын газрын дарга
- Гишүүдэд:
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
 - Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
 - Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирлагын хэлтсийн дарга
 - Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
 - Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
 - Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга
 - Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга
 - Аймгийн Цагдаагийн газрын дарга
 - Аймгийн Тагнуулын хэлтсийн дарга
 - Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга
 - Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламжийн захирагч
 - Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
 - Аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга
 - Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
 - Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга
 - Аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн дарга
 - Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
 - Аймгийн Мал эмнэлгийн газрын дарга
 - Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
 - “Мэдээлэл Холбооны Сүлжээ” ТӨХК-ний Дундговь салбарын дарга
 - Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
 - “Багануур Зүүн Өмнөд бүсийн Цахилгаан түгээх сүлжээ” Дундговь салбарын дарга
 - “Дундговь-Ус” ОНӨААТҮГ орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга
 - Аймгийн Автотээврийн төвийн дарга
 - Улаан загалмай нийгэмлэгийн Дундговь дахь салбарын дарга

- “Дундговь автозам” ХХК-ны захирал
- Сайнцагаан сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга: - Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах
төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2023 оны 05
дугаар сарын 03-ны өдрийн 497
дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймгийн Засаг дарга нь өөрийн харъяа Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хүрээнд Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Улсын нөөцийн тухай хуулиар хүлээсэн эрх үүргийн хүрээнд аюулт үзэгдэл, гал түймэр, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлт, химийн хордлогын улмаас хүн ам, мал амьтан хүрээлэн буй орчинд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулах, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавихдаа энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Аймгийн Онцгой комисс /цаашид комисс гэх нь/ Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль, бусад хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.

1.3. Аймгийн Онцгой комиссын бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга захирамжаар томилж баталгаажуулна.

1.4. Аймгийн Онцгой комиссын дарга нь сумын Онцгой комиссыг удирдлагаар хангах бөгөөд сумын Онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг тухайн шатны Засаг дарга батална.

1.5. Аймгийн Онцгой комиссын үйл ажиллагааг аймгийн Засаг дарга удирдах бөгөөд орлогч дарга нь аймгийн Засаг даргын орлогч, Онцгой байдлын газрын дарга нар байна.

1.6. Аймаг, орон нутгийн хэмжээнд гамшгийн нөхцөл байдал үүсч гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах үед гамшгаас хамгаалах удирдлагын байрыг байгуулах бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга удирдлагын байрны дарга байна.

1.7. Удирдлагын байрны дарга гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд хяналт тавьж, онцгой комиссын хуралдаан явагдах

цэгт удирдлагын байрыг байгуулж шаардлагатай тоног төхөөрөмж, холбоо харилцааны хэрэгслээр хангах арга хэмжээг зохион байгуулна.

1.8. Комиссын нэгдсэн хуралдаан нь нийт гишүүдийн 60-аас доошгүй хувийн ирцтэй бол хүчин төгөлдөр болох бөгөөд хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэж, хурлын тэмдэглэл хөтөлнө.

1.9. Гамшгийн нөхцөл байдал цаг үеийн асуудлаар комиссын шуурхай хуралдааныг холбогдох алба мэргэжлийн ангийн удирдлагын бүрэлдэхүүнтэйгээр хуралдаж шаардлагатай арга хэмжээг зохион байгуулна.

1.10. Комиссын дарга нь холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн эрх, үүрэг зорилтоо хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар захирамж, албан даалгавар, тушаал гаргана.

1.11. Комиссоос гарсан шийдвэрийг орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд, өмчийн хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

1.12. Комиссын хуралдааны товыг зарлан хуралдуулах, гамшгаас хамгаалах хойшлуулшгүй арга хэмжээг комиссын даргатай зөвшилцөн Онцгой байдлын газар зохион байгуулна.

Хоёр. Онцгой комиссын эрх, үүрэг

2.1. Онцгой комиссын үүрэг

2.1.1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах үйл ажиллагааг орон нутгийн төрийн захиргааны болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж иргэдийн оролцоотойгоор гүйцэтгүүлэх, Монгол Улсын Их хурал Засгийн газар Монгол Улсын Шадар Сайд Улсын онцгой комиссоос дээрх чиглэлээр өгсөн үүргийг хэрэгжүүлэх.

2.1.2. Гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих.

2.1.3. Гамшгийн нөхцөл байдалд мэргэжлийн болон холбогдох байгууллагуудын гаргасан үнэлэлт, дүгнэлтийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хэлэлцэн шийдвэр гаргах.

2.1.4. Гамшгийн голомтод болон нэрвэгдэгсдэд Засгийн газар, Олон улс, хүмүүнлэгийн байгууллагаас олгосон тусламжийн бараа материал, мөнгөн тусламжийг тээвэрлэн хүргэх, олгох үйл ажиллагаанд хяналт тавих.

2.1.5. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах хойшлуулшгүй сэргээн босгох нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх, хүч хэрэгслийг дайчлан гаргах үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулж хяналт тавих.

2.1.6. Гамшгийн аюулаас хүн ам, мал амьтан хүрээлэн буй орчныг хамгаалах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаа нь орон нутгийн дотоод нөөц боломжоор хэрэгжүүлэн боломжгүй тохиолдолд Улсын Онцгой комисс, Өмнөд бүсийн төв-Онцгой байдлын газарт уламжилан бүсийн хэмжээнд хамтран ажиллана.

2.1.7. Гамшгийн нөхцөл байдал урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байгаа үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээллийг олон нийтэд хүргэх.

2.1.8. Гамшгийн улмаас үүссэн нөхцөл байдлыг тогтоож үнэлэлт, дүгнэлт гаргах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох.

2.2. Онцгой комиссын эрх:

2.2.1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал, иргэдэд үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулахад хяналт тавина.

2.2.2. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд орон нутгийн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг хуулиар хүлээсэн эрх үүргийнх нь дагуу өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан татан оролцуулах.

2.2.3. Онцгой комиссын гишүүд холбогдох байгууллага албан тушаалтнаас шаардлагатай статистик тоон үзүүлэлт, мэдээ тайлан, судалгаа гаргуулах, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай танилцах.

2.2.4. Гамшигтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааг газар дээр нь шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг зохион байгуулах.

2.2.5. Комиссоос гарсан шийдвэр, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар зөвхөн Онцгой комиссын дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга мэдээллийг олон нийтэд хүргэнэ.

2.2.6. Онцгой комиссын гишүүд нэг төрлийн хувцас, үнэмлэхтэй байна.

2.2.7. Аймгийн Онцгой комисс нь хурлын тэмдэглэл, Онцгой комиссын шийдвэр, албан даалгавар, тушаал, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

Гурав. Сумын онцгой комиссын үүрэг

3.1. Сумын Онцгой комисс

3.1.1. Сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргын Захирамжийг үндэслэн сумын онцгой комисс / цаашид комисс гэх/-ын байгуулна.

3.1.2. Комиссын дарга нь сумын Засаг дарга, орлогч нь Тамгын газрын дарга байна.

3.1.3. Комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх, аймгийн Онцгой комиссоос үүрэг даалгаврын биелэлтийг хангах үүрэгтэй.

3.1.4. Сумын Онцгой комисс нь үүссэн нөхцөл байдал, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хэлэлцэн, шийдвэрийг хүсэлтийн хамт аймгийн онцгой комисст яаралтай ирүүлнэ.

3.1.5. Сумын нутаг дэвсгэрт тохиолдсон гамшгийн улмаас учирсан хохирлыг эхний ээлжинд гамшгаас хамгаалах нөөц сангийн хөрөнгөөс зарцуулах, хэрэв дээрхи хөрөнгөөс давсан тохиолдолд аймгийн онцгой комисст сумын Засаг даргын гамшгаас хамгаалах нөөц хөрөнгийн зарцуулалт, зарцуулалтын тайланг бичгээр ирүүлсэний дараа аймгийн Засаг даргын нөөц сангаас нэмэлт санхүүжилт гаргуулах хүсэлтээ ирүүлэх.

3.1.6. Комисс нь энэхүү журамд заасан үүргийг биелүүлж, эрхийг эдэлнэ.

Дөрөв. Комиссын зардал

4.1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь заалт аймгийн болон сумын тухайн жилийн төсвийн 1,0 хувийг орон нутгийн гамшгийн эрсдлийг бууруулах санд тусгаж, гамшгаас хамгаалах арга хэмжээнд зарцуулна гэсэн заалтийн дагуу гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хөрөнгө, зардлыг захиран зарцуулна.

Тав. Хохирол тогтоох ажлын хэсэг

5.1. Аймгийн Онцгой комисс нь гамшгийн улмаас учирсан хохирол тогтоох ажлын хэсэгтэй байна.

5.2. Хохиролын үнэлгээ тогтоох ажлын хэсгийг аймгийн Онцгой комисс томилно.

5.3. Хохирол тогтоох комисс нь гамшгийн улмаас үүссэн нөхцөл байдлыг тогтоож, баримтжуулан үнэлэлт, дүгнэлт гаргах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж гамшгийн нөхцөл байдал үүссэнээс хойш 14 хоногийн дотор эрх бүхий үнэлгээний байгууллагаар хохирлын үнэлгээг гаргуулна.

5.4. Хохирлын хэмжээг тогтоосны дараа аймгийн Онцгой комисст танилцуулж комиссоос гарсан шийдвэрийг үндэслэн хуулийн дагуу хохирлыг барагдуулах ажлыг зохион байгуулна.

5.5. Гамшгийн улмаас учирсан хохирол тогтоох үйл ажиллагааны зардлыг Онцгой комисс хариуцна.

Зургаа. Комиссын зардал

6.1. Онцгой комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөд тусган, зохих журмын дагуу захиран зарцуулна.

Долоо. Бусад зүйл

7.1. Онцгой комисс нь тухайн жилд гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг Онцгой комиссын даргаар батлуулан хэрэгжүүлж тайланг жил бүрийн 12 дугаар сард Улсын Онцгой комисст хүргүүлнэ.

7.2. Онцгой комисс нь гамшгийн үед зохион байгуулсан арга хэмжээ, үр дүнг гамшгийн нөхцөл байдал дууссаны дараа тухай бүр хэлэлцэж, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.

7.3. Онцгой комиссын ажиллах журамд орон нутгийн онцлогийг тусгасан нэмэлт заалт тусгаж болно.

7.4. Онцгой комиссоос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлээгүй байгууллага аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнд холбогдох хуулийн дагуу захиргааны шийтгэл ногдуулах саналаа эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх ба шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагаар шалгуулж шийдвэрлүүлнэ.